



НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТУГ
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 22-дээр

Дугаар 1128

Улаанбаатар хот

Г Залуучуудын зөвлөл байгуулах тухай

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан “Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр”-ийн 5.2.8 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


- Байгууллагын Залуучуудын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үүнд:

Захиргааны ажилтан	/Д.Номин-Эрдэнэ/
Хуулийн мэргэжилтэн	/Б.Ариунбилэг/
Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн	/Х.Бямбаа/
Төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн	/Н.Гантулга/
Бүтээн байгуулалт хариуцсан мэргэжилтэн	/Б.Батбилэг/
Маркетинг ОНХХ хариуцсан мэргэжилтэн	/Э.Энгүүн/
Гадаад харилцаа хамтын ажиллагаа	
хариуцсан мэргэжилтэн	/О.Чулуун-Эрдэнэ/

- Залуучуудын зөвлөлийн дурмийг хавсралтаар баталсугай.

3. Зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг анхдугаар хуралдаанаар хэлэлцэн сонгож, төлөвлөгөө гарган биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.



313060000089

Налайхын барилгын материалын үйлдвэрлэл,
технологийн парк ОНӨТҮҮЛСҮҮЛЭЛТЫН даргын оны
03..... дугаар сарын-ны өдрийн 11/09 дугаар
тушаалын хавсралт

TTB8651 № 5890683

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Залуучуудын хөгжлийн зөвлөл (цаашид “зөвлөл” гэх) нь залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг тухайн байгууллага болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвшилцлийн байгууллага мөн.

1.2. Зөвлөлийн үйл ажиллагааг энэхүү дүрмээр зохицуулна.

1.3. Зөвлөл нь Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, тэдгээртэй холбоотой бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийг дагаж мөрдөнө.

Хоёр. Үйл ажиллагааны зарчим

2.1 Зөвлөл нь залуучуудын хөгжлийг дэмжих төрийн болон орон нутгийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулахдаа хүний эрхэд суурилсан, мэргэжлийн ёс зүйтэй байх, хууль дээдлэх, оролцоонд тулгуурласан, шударга, ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан ажиллана.

Гурав. Эрхэм зорилго

3.1 Зөвлөлийн эрхэм зорилго нь залуучуудын өрсөлдөх чадвар, амьдралын чанарыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулан, тадний оролцоонд тулгуурлан хөгжих, салбар дундын ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Дөрөв. Удирдлага, зохион байгуулалт

4.1 Байгууллагын дэргэдэх залуучуудын зөвлөлийн Тэргүүнийг газрын дарга томилно.

4.2 Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүд гэсэн бүрэлдэхүүнтэй орон тооны бус зөвлөл байна.

4.3 Зөвлөл нь байгууллагын залуучуудын төлөөллөөс бүрдсэн 8 хүний бүрэлдэхүүнтэй байна.

4.4 Зөвлөл нь байгуулагдсан тухай хурлын тэмдэглэл, шийдвэр, бүрэлдэхүүний танилцуулгыг YDC.mn сайтад бүртгүүлж, батламж авч бүртгэл үүсгэх

Тав . Үйл ажиллагааны чиглэл

5.1. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, залуучуудын хөгжлийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг тухайн орон нутгийн залуучуудын салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулах.

5.2 залуучуудын эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцож, тэдний саналыг хүргэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатай мэдээллээр хангах

5.3 залуучуудын хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээнд тулгуурласан, эерэг хандлага зан үйлд уриалсан үйл ажиллагаа явуулах оролцооны байгууллагуудын сайн дурын үйл ажиллагааг дэмжих

5.4 Холбогдох хууль, дүрэм, эрх зүйн бусад акт, дээд газраас ирүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах

Зургаа. Зөвлөлийн хуралдаан гишүүдийн үүрэг

6.1. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн төрийн албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөн ажиллана.

6.2. Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохицуулж, хуралдааны бэлтгэлийг ханган гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг нэгтгэн салбар зөвлөлийн тэргүүн, дэд тэргүүн, гишүүдийг мэдээллээр хангана.

6.3. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, хагас жил болон жилийн эцсийн тайланг салбар зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

6.4. Зөвлөлийн хуралдааны тов болон хэлэлцэх асуудлыг зөвлөлийн тэргүүн батална.

6.5. Зөвлөлийн тэргүүн, эсхүл зөвлөлийн нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь тодорхой асуудлаар хуралдах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тэргүүний шийдвэрээр ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулна.

- 6.6. Зөвлөлөөс гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 6.7. Нийт гишүүдийн 50-иас дээш хувь оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.
- 6.8. Хуралдааны ирц бүрдээгүй тохиолдолд хуралдааныг ажлын 10 хоногийн дотор дахин зарлан хуралдуулна.
- 6.9. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд биеэр оролцох боломжгүй гишүүн хурал эхлэхээс өмнө саналаа бичгээр хүргүүлж болно.
- 6.10. Хуралдаанд холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулж болно.
- 6.11. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэж тогтоол, зөвлөмж гаргана.
- 6.12. залуучуудын хөгжил, хамгааллын асуудлаар санал, санаачилга гаргаж салбарын хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулах, хэрэгжилтийг дэмжих, хяналт үнэлгээ хийх;
- 6.13 тухайн салбарын бодлого, хөтөлбөрт залуучуудын хөгжил, хамгаалал, аж байдлыг сайжруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээ тусгуулж, хэрэгжилтэд оролцох;
- 6.14 залуучуудад зориулан хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх сургалт зохион байгуулахыг дэмжих;

Долоо. Залуучуудын зөвлөлийн үйл ажиллагаанд хориглох зүйл

- 7.1 Зөвлөлийн үйл ажиллагаанд улс төрийн нам, эвсэл, шашны үйл ажиллагааг сурчилах
- 7.2 Аливаа байгууллагын болон хувь хүний нэр хүндэд халдах, гутгэх, гутаан доромжлохыг
- 7.3 Ашиг олох зорилгоор үйл ажиллагаа явуулахгүй байх.